



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/825

Арвайхээр

Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын  
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 40, 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хянаж зөвшөөрөл олгосон сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Оюунгэрэл) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/145 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101581

Аймгийн Засаг даргын 2019 оны 19  
дугаар сарын 30-ны өдрийн 4825 дугаар  
захирамжийн хавсралт



ТӨГРӨГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Тамгын газрын дарга	1
4.	Санхүүгийн албаны дарга	1
5.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
6.	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
7.	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	1
8.	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
9.	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
10.	Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Нягтлан бодогч	1
13.	Багийн Засаг дарга	5
14.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
15.	Нярав-үйлчлэгч	1
16.	Жолооч	1
	Бүгд	20